



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар N341

Номгон

「Инженерийн хийцтэй уст цэг шинээр гаргах
газрын нэр, байршил батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."а", Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8.1.12, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Баян-Овоо, Богд, Баянговь, Жаргалант, Баянлиг сумдад шинээр худаг, уст цэг гаргах газрын байршил, нэрийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгарсан "Чорьж Бүрд" ХХК-тай гэрээ байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай

3.Инженерийн хийцтэй уст цэг гаргах ажлыг чанартай гүйцэтгэхийг "Чорьж Бүрд" ХХК-д, ашиглалт, эзэмшилт, хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

621010869

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын
28-ны өдрийн А/341 дүгээр захирамжийн
хавсралт



ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ УСТ ЦЭГ ШИНЭЭР
ГАРГАХ СУМЫН НЭР, БАЙРШИЛ

Д/д	Сумын нэр	Багийн нэр	Газрын нэр
1.	Баян-Овоо	1-р баг	Шар бүрд
2.	Баянлиг	3-р баг	Хонгор
3.	Богд	2-р баг	Элсэн гээг
4.	Баянговь	3-р баг	Зараа толгой
5.	Жаргалант	1-р баг	Талын толгой

_____ оОо _____